



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар A/80

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалт "Гаүли ҮЦК" ХХК-ийн 2018 оны 18/113 дугаартай албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гишүүн "Гаүли ҮЦК" ХХК-ийн ажилтан /Ж.Мөнхбаатар/-д үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000278